АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Хангай сумын ЭМТ-ийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2024/210/-НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.open.audit.mn<br>Архангай аймаг<br>2023 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br>Гэрээгээр аудит гүйцэтгэсэн:<br>Бизкон аудит ХХК Архангай аймаг дахь салбар<br>Ахлах аудитор Ч.Анхбаяр<br>Утас: 8511-6555<br>Цахим хаяг: ankha964@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

**1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** 3
Аудитын гол асуудал **Error! Bookmark not defined.**
**2.** АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 8
**3.** САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв 11
3.5.3 Нэмэлт төсөв 12
3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл 12
**4.** АУДИТЫН ТАЙЛАН 12
4.1 Ерөнхий зүйл 12
4.2 Материаллаг байдал 13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал 15
**5.** АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ 15
5.2 Зөвлөмж 15
**6.** АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ 16

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| БГАҮТХ | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |
| ЭМГ | Эрүүл мэндийн газар |
| ЭМДС | Эрүүл мэндийн даатгалын сан |
| ЭМТ | Эрүүл мэндийн төв |

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.02.25 № 229

танай ____________-ны №____________-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ХАНГАЙ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Я.БАЯСГАЛАН ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хангай сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хангай сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

Тайлант онд Эрүүл мэндийн төвийн даргын тушаалаар албан хаагчдад нийт 11,285.0 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлтийг батлагдсан цалингийн сангаас хавтгайруулан олгосон байна

Энэ зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6.4.1, 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.1 дэх заалтад нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Хангай сумын ЭМТ нь тайлант онд ЭМЯ-аас 33,286.2 мянган төгрөгийн бараа материал, 12,343.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсныг санхүүгийн тайланд тусгасан байна.

### Аудитын гол асуудал

Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 22.1 хувиар өссөн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 үндсэн зорилтын хүрээнд 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг Хангай сумын Засаг дарга 94 хувиар үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

# 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 282,144,527.29 | 341,376,722.76 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 58,577,195.10 | 43,353,837.04 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 58,577,195.10 | 43,353,837.04 |
| 3121 | Төгрөг | 58,577,195.10 | 43,353,837.04 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 58,577,195.10 | 43,353,837.04 |
| 33 | АВЛАГА | - | 11,407,093.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | - | 11,407,093.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 223,567,332.19 | 286,615,792.72 |
| 351 | Түүхий эд материал | 202,368,991.99 | 252,651,533.52 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 81,504,227.88 | 96,811,444.03 |
| 35130 | Эм боох материал | 120,864,764.11 | 155,840,089.49 |
| 354 | Хангамжийн материал | 21,198,340.20 | 33,964,259.20 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,637,477.00 | 3,046,777.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 15,931,993.70 | 17,619,962.70 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,177,000.00 | 9,662,500.00 |
| 35460 | Хүнсний материал | 2,276,869.50 | 3,635,019.50 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 175,000.00 | - |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 604,403,175.16 | 587,347,026.51 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 604,403,175.16 | 587,347,026.51 |
| 392 | Биет хөрөнгө | 597,040,675.10 | 579,984,526.45 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 410,203,419.24 | 410,203,419.24 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | - 18,514,530.18 | - 26,033,675.58 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 207,066,462.21 | 207,066,462.21 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | - 82,209,998.67 | - 107,046,901.45 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 136,522,898.67 | 157,866,744.17 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | - 86,329,456.47 | - 91,024,485.80 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 37,972,439.40 | 37,972,439.40 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | - 7,702,559.10 | - 9,051,475.74 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 3,509,408.98 | 3,509,408.98 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | - 3,477,408.98 | - 3,477,408.98 |
| 393 | Биет бус хөрөнгө | 7,362,500.06 | 7,362,500.06 |
| 39301 | Програм хангамж | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | - 937,499.94 | - 937,499.94 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 6,800,000.00 | 6,800,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 886,547,702.45 | 928,723,749.27 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 886,547,702.45 | 928,723,749.27 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 886,547,702.45 | 928,723,749.27 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 611,535,526.03 | 611,535,526.03 |
| 51101 | Өмч: - төрийн | 611,535,526.03 | 611,535,526.03 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 224,091,862.71 | 268,200,601.73 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 224,091,862.71 | 224,091,862.71 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 44,108,739.02 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 50,920,313.71 | 50,920,313.71 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 886,547,702.45 | 928,723,749.27 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,518,965,763.59 | 848,120,737.45 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 821,634,033.59 | 46,703,439.78 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 821,634,033.59 | 46,703,439.78 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 0.00 | 1,019,680.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.00 | 1,019,680.00 |
| 120009 | Бусад орлого | 0.00 | 53,634.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 581,465,441.78 | 12,343,845.50 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 240,168,591.81 | 33,286,280.28 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 697,331,730.00 | 801,417,297.67 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 32,850,000.00 | 42,233,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 32,850,000.00 | 42,233,100.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 664,481,730.00 | 759,184,197.67 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 664,481,730.00 | 759,184,197.67 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 681,808,269.86 | 805,944,690.63 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 681,808,269.86 | 805,944,690.63 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 681,793,611.86 | 805,616,374.46 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 419,265,713.62 | 517,433,165.73 |
| 210101 | Үндсэн цалин | 253,048,779.90 | 252,017,558.64 |
| 210102 | Нэмэгдэл | 98,766,177.27 | 203,925,036.41 |
| 210104 | Урамшуулал | 42,551,090.31 | 39,936,662.68 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 24,899,666.14 | 21,553,908.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 51,719,100.00 | 67,424,676.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,169,000.00 | 46,028,349.75 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,137,600.00 | 5,359,446.98 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,310,000.00 | 4,286,597.59 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 827,500.00 | 1,067,679.98 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,275,000.00 | 10,682,601.70 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 23,581,842.00 | 22,719,283.83 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,065,842.00 | 8,111,783.83 |
| 210302 | Түлш, халаалт | 17,466,000.00 | 14,557,500.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 50,000.00 | 50,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 56,441,615.70 | 61,541,074.85 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,752,000.00 | 4,765,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 26,212,000.00 | 34,317,360.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,842,100.00 | 2,728,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 504,800.00 | 816,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,552,365.70 | 14,198,414.85 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 18,578,350.00 | 4,715,900.00 |
| 2105 | Нормативт зардал | 103,504,965.92 | 81,695,129.90 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 90,304,403.92 | 69,181,429.90 |
| 210502 | Хоол, хүнс | 6,868,562.00 | 12,338,700.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,332,000.00 | 175,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,197,000.00 | 5,274,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,197,000.00 | 5,274,700.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,300,000.00 | 6,297,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,300,000.00 | 6,297,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 250,510.00 | 537,450.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.00 | 450,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 73,700.00 | 87,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 110,000.00 | 1.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 66,810.00 | 1.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,532,864.62 | 42,693,894.15 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,668,998.00 | 4,293,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 9,863,866.62 | 38,399,994.15 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 14,658.00 | 328,316.17 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 14,658.00 | 328,316.17 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 14,658.00 | 328,316.17 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 837,157,493.73 | 42,176,046.82 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 837,157,493.73 | 42,176,046.82 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 746,721,938.72 | 791,083,518.67 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 5,385,808.72 | 1,073,314.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 5,385,808.72 | 1,073,314.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 5,385,808.72 | 1,019,680.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.00 | 1,019,680.00 |
| 1200047 | Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө | 5,385,808.72 | 1.00 |
| 120009 | Бусад орлого | 0.00 | 53,634.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 741,336,130.00 | 790,010,204.67 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 32,850,000.00 | 42,233,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 32,850,000.00 | 42,233,100.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 708,486,130.00 | 747,777,104.67 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 708,486,130.00 | 747,777,104.67 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 655,343,143.62 | 797,306,876.73 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 655,343,143.62 | 797,306,876.73 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 655,328,485.62 | 796,978,560.56 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 419,265,713.62 | 517,433,165.73 |
| 210101 | Үндсэн цалин | 253,048,779.90 | 252,017,558.64 |
| 210102 | Нэмэгдэл | 98,766,177.27 | 203,925,036.41 |
| 210104 | Урамшуулал | 42,551,090.31 | 39,936,662.68 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 24,899,666.14 | 21,553,908.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 51,719,100.00 | 67,424,676.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,169,000.00 | 46,028,349.75 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,137,600.00 | 5,359,446.98 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,310,000.00 | 4,286,597.59 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 827,500.00 | 1,067,679.98 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,275,000.00 | 10,682,601.70 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 27,835,342.00 | 35,904,783.83 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,065,842.00 | 10,799,283.83 |
| 210302 | Түлш, халаалт | 21,719,500.00 | 24,840,700.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 50,000.00 | 264,800.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 36,015,300.00 | 40,866,700.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,074,500.00 | 3,360,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 26,117,000.00 | 29,103,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,842,100.00 | 2,728,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,500,000.00 | 1,020,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,481,700.00 | 4,654,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 53,141,572.00 | 89,196,625.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 42,955,522.00 | 70,394,475.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8,120,050.00 | 13,051,850.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,066,000.00 | 5,750,300.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 47,244,950.00 | 22,062,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 27,476,950.00 | 4,835,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 19,768,000.00 | 17,227,900.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,300,000.00 | 6,297,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,300,000.00 | 6,297,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 250,510.00 | 537,450.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.00 | 450,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 73,700.00 | 87,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 110,000.00 | 1.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 66,810.00 | 1.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,555,998.00 | 17,255,260.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,555,998.00 | 17,255,260.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 14,658.00 | 328,316.17 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 14,658.00 | 328,316.17 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 14,658.00 | 328,316.17 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 91,378,795.10 | -6,223,358.06 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 32,801,600.00 | 9,000,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 32,801,600.00 | 9,000,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 32,801,600.00 | 9,000,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 32,801,600.00 | 9,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -32,801,600.00 | -9,000,000.00 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 58,577,195.10 | -15,223,358.06 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 58,577,195.10 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 58,577,195.10 | 43,353,837.04 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 611,535,526.03 | 50,920,313.71 | -613,065,631.02 | 49,390,208.72 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 611,535,526.03 | 50,920,313.71 | -613,065,631.02 | -613,065,631.02 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 837,157,493.73 | 837,157,493.73 |
| C08 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 611,535,526.03 | 50,920,313.71 | 224,091,862.71 | 224,091,862.71 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 42,176,046.82 | 42,176,046.82 |
| D09 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 611,535,526.03 | 50,920,313.71 | 266,267,909.53 | 928,723,749.27 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 862,207,100.00 | 805,978,560.56 | 56,228,539.44 | 93.48 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 862,207,100.00 | 805,978,560.56 | 56,228,539.44 | 93.48 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 862,207,100.00 | 805,978,560.56 | 56,228,539.44 | 93.48 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 549,414,500.00 | 517,433,165.73 | 31,981,334.27 | 94.18 |
| 210101 | Үндсэн цалин | 248,702,700.00 | 252,017,558.64 | -3,314,858.64 | 101.33 |
| 210102 | Нэмэгдэл | 233,585,000.00 | 203,925,036.41 | 29,659,963.59 | 87.30 |
| 210104 | Урамшуулал | 48,976,500.00 | 39,936,662.68 | 9,039,837.32 | 81.54 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 18,150,300.00 | 21,553,908.00 | -3,403,608.00 | 118.75 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 69,016,000.00 | 67,424,676.00 | 1,591,324.00 | 97.69 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 47,084,500.00 | 46,028,349.75 | 1,056,150.25 | 97.76 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,483,700.00 | 5,359,446.98 | 124,253.02 | 97.73 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,386,000.00 | 4,286,597.59 | 99,402.41 | 97.73 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,096,000.00 | 1,067,679.98 | 28,320.02 | 97.42 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,965,800.00 | 10,682,601.70 | 283,198.30 | 97.42 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 36,233,100.00 | 35,904,783.83 | 328,316.17 | 99.09 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,000,000.00 | 10,799,283.83 | 200,716.17 | 98.18 |
| 210302 | Түлш, халаалт | 23,913,100.00 | 24,840,700.00 | -927,600.00 | 103.88 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,320,000.00 | 264,800.00 | 1,055,200.00 | 20.06 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 43,539,200.00 | 40,866,700.00 | 2,672,500.00 | 93.86 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,350,000.00 | 3,360,500.00 | 989,500.00 | 77.25 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 29,103,900.00 | 29,103,900.00 | 0.00 | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,810,300.00 | 2,728,300.00 | 82,000.00 | 97.08 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,400,000.00 | 1,020,000.00 | 1,380,000.00 | 42.50 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,875,000.00 | 4,654,000.00 | 221,000.00 | 95.47 |
| 2105 | Нормативт зардал | 94,786,300.00 | 89,196,625.00 | 5,589,675.00 | 94.10 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 74,594,500.00 | 70,394,475.00 | 4,200,025.00 | 94.37 |
| 210502 | Хоол, хүнс | 13,441,500.00 | 13,051,850.00 | 389,650.00 | 97.10 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,750,300.00 | 5,750,300.00 | 1,000,000.00 | 85.19 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 38,875,300.00 | 31,062,900.00 | 7,812,400.00 | 79.90 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 16,000,300.00 | 13,835,000.00 | 2,165,300.00 | 86.47 |
| 210604 | Урсгал засвар | 22,875,000.00 | 17,227,900.00 | 5,647,100.00 | 75.31 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,297,000.00 | 6,297,000.00 | 0.00 | 100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,297,000.00 | 6,297,000.00 | 0.00 | 100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 962,000.00 | 537,450.00 | 424,550.00 | 55.87 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 550,000.00 | 450,000.00 | 100,000.00 | 81.82 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 120,000.00 | 87,450.00 | 32,550.00 | 72.88 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 42,000.00 | - | | |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 250,000.00 | - | | |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,083,700.00 | 17,255,260.00 | 5,828,440.00 | 74.75 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,083,700.00 | 17,255,260.00 | 5,828,440.00 | 74.75 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 862,207,100.00 | 790,755,202.50 | 71,451,897.50 | 91.71 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 42,233,100.00 | 41,904,783.83 | 328,316.17 | 99.22 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 42,233,100.00 | 41,904,783.83 | 328,316.17 | 99.22 |
| 1340 | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 760,377,200.00 | 747,777,104.67 | 12,600,095.33 | 98.34 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 760,377,200.00 | 747,777,104.67 | 12,600,095.33 | 98.34 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 59,596,800.00 | 1,073,314.00 | 58,523,486.00 | 1.80 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,019,600.00 | 1,019,680.00 | -80.00 | 100.01 |
| | Бусад орлого | 0.00 | 53,634.00 | -53,634.00 | 0.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 58,577,200.00 | | 58,577,200.00 | 0.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 58,577,195.10 | -58,577,195.10 | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 43,353,837.04 | -43,353,837.04 | |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 30 | 30 | - | 100 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 20 | 20 | - | 100 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5 | 5 | - | 100 |
| 620004 | Гэрээт ажилтан | 4 | 4 | - | 100 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 516,538.9 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг залруулсан.

Залруулсан алдаа:

- Цалингийн зардлын дансны бичилтийг шалгахад 1-12 сарын 516,538.9 мянган төгрөгийн олговол зохих цалингийн дүнгээр цалингийн зардлын данс руу бичилт хийгээгүй, цалингийн суутгалуудаас зардал бичилт хийсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1-р хавсралтаар баталсан “Төсөвт байгууллагуудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг зөрчсөн, ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 23,495.0 мянган төгрөгийн зөрчил [1] илэрснээс, 1 албан шаардлага, 1 зөвлөмжийг хүргүүллээ.

Аудитаар илэрсэн 11,285.0 мянган төгрөгийн залруулагдаагүй 1 зөрчилтэй асуудал нь гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 7,499.7 мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

### 3.1 Албан шаардлага

3.1.1 Эдийн засгийн ангиллаар төсөв хуваарилагдаагүй байхад ажилтнуудад 11,285.0 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлтийг цалингийн сангаас олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1 “зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 10 сарын 29-ний өдрийн 190 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

<u>*Шийдвэрлэсэн нь*</u>: Зөрчлийг таслан зогсоох байх албан шаардлага хүргүүллээ

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Төсөв хөрөнгөөр худалдан авсан өнгөт принтер, компьютер, гадна, дотор камер болох үндсэн хөрөнгийг аж ахуйн бараа материалын дансанд 12,210.0 мянган төгрөгөөр бүртгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, УСНББОУС 17-д "Үндсэн хөрөнгийн зүйлийг дараах тохиолдолд хөрөнгө хэмээн хүлээн зөвшөөрнө”, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.3. "Энэ журмын 4.1.1-д заасан хөрөнгийг хүлээн авч буй хуулийн этгээд тухайн иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрлийг албан ёсоор авч үндсэн болон эргэлтийн хөрөнгөөр нь ангилан, ашиглах хугацаа, чанар байдлыг нь харгалзан ашигласан хугацааны элэгдэл, хорогдлын шимтгэлийг тооцож данс бүртгэлдээ тусгана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*Өгсөн зөвлөмж*: Үндсэн хөрөнгийг ТӨБЗГ-ын 271 дүгээр тогтоолын дагуу зөв ангилан бүртгэж тайлагнах арга хэмжээ авах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 03 дугаар сарын 22-ны дотор ирүүлнэ үү.

*Зөвлөмжийн биелэлтийг тооцож, нотлох баримтыг хангуулан 2024 оны 06 дугаар сарын 20-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.*

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үгүйсгэс: Залруулсан | | Үгүйсгэс: Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Цалингийн зардлын дансны бичилт буруу хийсэн | 1 | 516,538.9 | | | 1 | 516,538.9 | 1 | 516,538.9 | | | | |
| Дүн | 1 | 516,538.9 | | | 1 | 516,538.9 | 1 | 516,538.9 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үгүйсгэс: Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| ААМ-д үндсэн хөрөнгөнд бүртгэсэн | 1 | 12,210.0 | | | | | 1 | 12,210.0 | | | | |
| Цалингийн сангаас түлшний мөнгө олгосон | 1 | 11,285.0 | | | 1 | 11,285.0 | | | | | | |
| **Дүн** | **2** | **23,495.0** | | | 1 | 11,285.0 | 1 | 12,210.0 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үгүйсгэс: Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Мэдээлэл дутуу байршуулсан | 1 | 0 | | | 1 | 0 | | |
| Дүн | 1 | 0 | | | 1 | 0 | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй | 1 | 0 | | | 1 | 0 | | |
| Дүн | 1 | 0 | | | 1 | 0 | | |
| **Нийт дүн** | | | | | | | | |